

Петро Матад Лимитэд (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)

Захирлыг өөрчлөх тухай

Петро Матадын Захирлуудын Зөвлөл (ЗЗ) хатагтай Даваанямын Энхмааг Компанийн Гүйцэтгэх-бус захирлаар томилж, даруй хүчин төгөлдөр болгосноо зарлахдаа таатай байна. Хатагтай Энхмаа ЗЗ-ын Компанийн засаглал, Нийгмийн үйл ажиллагаа, Хүрээлэн буй орчны Хороо (КЗНҮАХБОХ) –ны бүрэлдэхүүнд орж ажиллахаар мөн томилогдлоо. Энхмаа нь Петро Матадын хамгийн том хувьцаа эзэмшигч Петровис ХХК (“Петровис”)-аас нэр дэвшсэн ба Петро Матадын захирлын ажлаас чөлөөлөгдөөд байгаа Даваанямын Энхчимэгийн оронд томилогдож байгаа юм.

Энхмаа нь (32 настай) Монголд оршин суудаг, хөрөнгө оруулалтын банкир мэргэжилтэй, одоогоор “Макуайэри Капитал Адвайсэрс” (Macquarie Capital Advisers) –ын Монгол дахь салбарыг хариуцсан тэргүүнээр ажиллаж буй. Энхмаа Макуайэри Групп компаниудад сүүлийн 9 жилийн турш, эрчим хүч, ашигт малтмалын болон дэд бүтцийн салбарын чиглэлээр голлон ажиллаж ирсэн. Одоо гүйцэтгэж буй “Макуаэри Капитал Адвайсэрс”-ийн зөвлөхийн ажлаасаа өмнө Америкийн Нэгдсэн Улс дахь “Макуайэри Групп”-д эрчим хүчний салбарын эрсдлийн удирдлага хариуцсан Захирлаар ажиллаж байсан.

ЗЗ-д орж буй өөрчлөлтийн талаар Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал (ЕГЗ) Даглас МакГэй тайлбарлаж хэлэхдээ:

“Бид Хатагтай Энхмааг Захирлуудын Зөвлөлийн бүрэлдэхүүндээ оруулж байгаадаа баяртай байна. Түүний эрчим хүчний салбарын болон банкны салбарын туршлага, ур чадвар, ялангуяа газрын тос, байгалийн хийн салбарын туршлага нь Компанид үнэ цэнэ нэмж буй хэрэг бөгөөд бид түүний ур чадварыг үр дүнтэй ашиглах болно. Мөн Захирлуудын Зөвлөл, Хатагтай Энхчимэгийн тус компанид оруулсан үнэтэй хувь нэмрийг тэмдэглэж, талархахыг хүсч байна.” гэжээ.

Хатагтай Энхмаа, “Ассэнд Файнаншэл Групп” (Ascend Financial Group Ltd) компанийн захирал бөгөөд Компаниудад зориулсан Эй Ай Эм (AIM)-ийн Дүрмийн Хуваарь 2 -ийн (g) хэсэгт заасны дагуу ямар нэг өөр бусад захирлын алба хашдаггүй гэдгийг баталгаажуулсан болно.

Редакторуудад зориулсан санамж:

Петро Матад Лимитэдийн тухай

Петро Матад бол газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монголын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий Матад ХХ -н БХГ юм Нөгөө хоёр талбай болох Богд IV, Онги V талбайнууд нь Монгол орны төв хэсэгт 71,040км² талбайг эзлэн оршдог.

Петро Матад Лимитэд нь 1483V гэсэн бүртгэлийн дугаартайгаар Айл оф Мэн (Isle of Man)-д үүсгэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспект Хилл, Дуглас, Айл оф Мэн, Ай Эм1 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ.)

Нэмэлт мэдээллийг:

ПетроМатад Лимитэд
Даглас Жэй. МакГэй - ЕГЗ
+976 11 331099

Уэст Хауз Секьюритиз Лимитэд (Westhouse Securities Limited)
Ричард Бэти/ Питр Нортон (Richard Baty / Petre Norton)
+44 (0)20 7601 6100